



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 9/583

Улаанбаатар хот


Г Түр заавар батлах тухай Т

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.1 дэх заалт, Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Томуугийн харуулдан тандалтын тогтолцоонд суурилан Коронавируст халдварт /КОВИД-19/-ын тандалтыг өргөжүүлэх түр заавар”-ыг нэгдүгээр, “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын лабораторийн сорьц авах, хадгалах, тээвэрлэх, мэдээллийн урсгалын түр журам”-ыг хоёрдугаар, “Эрсдэлт бүлгийн хүн амын дунд идэвхтэй тандалт зохион байгуулах түр заавар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Коронавируст халдварт /КОВИД-19/-ын харуулдан тандалтыг өргөжүүлэн зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дарга, захирал, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
- Вирус судлалын салбар лабораториудын урвалж, оношлуурын зардлыг жил бүрийн улсын төсөөт тусгаж ажиллахыг тухайн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.


САЙД

Т. МӨНХСАЙХАН



141202406

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны 12 сарын 17-ны өдрийн тушаалын  
нэгдүгээр хавсралт



## ТОМУУГИЙН ХАРУУЛДАН ТАНДАЛТЫН ТОГТОЛЦООНД СУУРИЛАН КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАНДАЛТЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ ТҮР ЗААВАР

### Нэг. Үндэслэл

Монгол Улсын хэмжээнд томуугийн харуулдан тандалтын тогтолцоо нь амбулаторид суурилсан 115, эмнэлэгт суурилсан 37 нэгжээс жилийн турш томуу, томуу төст өвчин (ТТӨ), амьсгалын замын цочмог хүнд халдварт (АЗЦХХ)-ын тандалт хийж, дэгдэлтийг эрт илрүүлэх, дүн шинжилгээ хийх, тохиолдлын тодорхойлолтод тохирсон өвчтөнийг бүртгэн мэдээлж, хамар залгиурын арчдас цуглуулан шинжилж, үр дүнг эргэн мэдээлдэг.

Томуугийн харуулдан тандалтын тогтолцоонд суурилан Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тандалтыг өргөжүүлснээр шинэ тохиолдлыг эрт илрүүлэх, харуулдан тандалт хийх, лабораторийн шинжилгээг тогтмолжуулах, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээллээр хангах, нотолгоонд суурилсан хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

### Хоёр. Зорилго

Томуугийн харуулдан тандалтын тогтолцоог өргөжүүлж, коронавируст халдварт (КОВИД-19)-ыг эрт илрүүлэх, харуулдан тандалт хийх, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх.

### Гурав. Зорилт

3.1. Томуугийн тандалтын тогтолцоог эрчимжүүлэн өргөжүүлж, Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тохиолдлыг эрт илрүүлэх, зэрэглэл харгалзахгүй сорьц цуглуулах;

3.2. Томуугийн тандалтын одоогийн тогтолцоог өргөжүүлж, амбулаторид суурилсан 14, эмнэлэгт суурилсан 7, нийт 21 нэгжийг нэмэгдүүлэх;

3.3. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тархалтын үе шатанд тохируулан хүн амын дунд идэвхтэй тандалт, илрүүлэг зохион байгуулах.

### Дөрөв. Тохиолдлын тодорхойлолт

4.1. ТТӨ: Сүүлийн 10 хоногт гэнэт 38 хэм, түүнээс дээш өндөр халуурах, ханиалгах зэрэг эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн амьсгалын цочмог халдвартын тохиолдлыг хэлнэ (J00-J22).

4.2. АЗЦХХ: ТТӨ-ий шинж тэмдэг бүхий өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай тохиолдлыг хэлнэ (J00-J22).

4.3. Голомтолсон өвчлөл: Нэг бүлэг, хамт олны дунд 2 ба түүнээс дээш хүнд 10 хоногийн хугацаанд эмнэлзүйн адил шинж тэмдэг гэнэт илрэхийг хэлнэ.

#### 4.4. Коронавируст халдвэр (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдол<sup>1</sup>

А. Тархвар судлалын өгүүлэлмжтэй, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн хүн

Эмнэлзүйн шалгуур үзүүлэлт:

- Гэнэт халуурах, ханиалгах;

ЭСХҮЛ:

- Дараах шинж тэмдгээс дор хаяж ГУРАВ нь илэрсэн: халуурах, ханиалгах, тамирдах/ядрах, толгой, булчин, хоолой өвдөх, ханиалгах, амьсгал тасалдах, хоолны дуршил буурах, дотор муухайрах, бөөлжих, суулгах, сэтгэл санаа тавгүйрхэх, үнэрлэх, амтлах мэдрэхүй алдагдах;

Тархвар судлалын шалгуур үзүүлэлт:

- Шинж тэмдэг илрэхээс өмнөх 14 хоногийн хугацаанд вирус тархах өндөр эрсдэлтэй газарт оршин суух буюу ажиллаж амьдарч байсан өгүүлэлмжтэй;

ЭСХҮЛ

- Шинж тэмдэг эхлэхээс өмнөх 14 хоногийн хугацаанд эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байсан өгүүлэлмжтэй;

ЭСХҮЛ

- Шинж тэмдэг эхлэхээс өмнөх 14 хоногийн хугацаанд эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байсан өгүүлэлмжтэй.

Б. Халуурах (халууныг үзсэн болон тэмдэглэгээ) + ханиалгах эсвэл амьсалахад бэрхшээлтэй болох + эмнэлэгт хэвтсэн тохиолдлыг хэлнэ.

Дээрх тохиолдлын тодорхойлолтод тохирсон өвчтнөөс эмч эмчилгээ эхлэхээс өмнө сорьц авна. Нэг 7 хоногт 10-15 сорьц цуглуулна. ТТӨ-ий дэгдэлтийн үед 7 хоногт 2 удаагийн давтамжтай авч болно.

**Тав. Тандалтын нэгжийн ангилал, мэдээлэл солилцоо, хэрэгжүүлэх арга хэмжээ**

5.1. Томуугийн харуулдан тандалтын I зэрэглэлийн нэгжүүдэд Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 2.3 заалтанд орсон Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Ховд, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвүүд, нэгдсэн эмнэлэг, Улаанбаатар хотын 8 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 23 өрхийн эрүүл мэндийн төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ), Халдварт өвчин судлалын үнэдсний төв (ХӨСҮТ) багтана.

5.2. Томуугийн харуулдан тандалтын II зэрэглэлийн нэгжүүдэд Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 2.3 заалтанд ороогүй аймгийн төвийн өрхийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, Сэлэнгэ аймгийн Мандал, Дорноговь аймгийн Замын-Үүд, Өвөрхангай аймгийн Хархорин сумын эрүүл

<sup>1</sup> Тохиолдлын тодорхойлолт, 2020 оны 12-р сарын 7-ны өдөр шинэчлэгдсэн, ДЭМБ

мэндийн төв, Улаанбаатар хотын Улсын нэгдүгээр төв эмнэлэг (УНТЭ), Улсын гуравдугаар төв эмнэлэг (УГТЭ), Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ) багтана.

5.3. Томуугийн харуулдан тандалтын нэмэлт нэгжүүдэд Улсын хоёрдугаар төв эмнэлэг (УХТЭ), Нийслэлийн “Өргөө”, “Амгалан”, “Хүрээ” амаржих газрууд, Батлан хамгаалах яамны харьяа Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг, Цэргийн төв эмнэлэг, Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Улаанбаатар төмөр замын төв эмнэлэг, хилийн боомттой аймаг, сумдын амбулаториид суурилсан 14, эмнэлэгт суурилсан 7, нийт 21 нэгжийг нэмэгдүүлэн хамруулна (Хүснэгт 1).

5.4. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тандалтын хүрээнд томуугийн харуулдан тандалтын амбулаториид суурилсан 2-р зэрэглэлийн 54, эмнэлэгт суурилсан 20 нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлж 7 хоногт 2 удаа сорьц цуглуулах, нэмэлтээр 21 нэгжээр өргөжүүлэн тандалтыг зохион байгуулна.

5.5. Томуугийн харуулдан тандалтын нэгж (ТХТН)-үүд нь ТТӨ, АЗЦХХ-ын тоон мэдээг Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, 2020 оны 482 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-ийн Томуугийн үндэсний нэгж (ТҮН)-ийн [www.flu.mn](http://www.flu.mn) цахим хуудсаар батлагдсан маягтын дагуу мэдээлнэ.

5.6. Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, бусийн оношилгоо эмчилгээний төвийн халдварт судлагч эсвэл дүн бүртгэгч нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны 482 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан “Маягт 1”, “Маягт 2” -ын дагуу өдөр бүр [www.burtgel.mohs.mn](http://www.burtgel.mohs.mn) цахим хуудсаар ХӨСҮТ-ийн ТҮН-д 12 цагаас өмнө тогтмол мэдээлнэ.

5.7. АЗЦХХ-ын шалтгаантай нас барсан тохиолдол бүрийг халдварт судлагч эсвэл дүн бүртгэгч нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны 482 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан “Маягт 4”-ийн дагуу 48 цагийн дотор ХӨСҮТ-ийн ТҮН-д тогтмол мэдээлнэ.

5.8. Тандалтын долоо хоног, өдөр тутмын мэдээг [www.flu.mn](http://www.flu.mn), [www.burtgel.mohs.mn](http://www.burtgel.mohs.mn) цахим хуудсаар батлагдсан маягтын дагуу хугацаанд нь баталгаажуулж мэдээлнэ. Заасан хугацаанаас хойш ирүүлсэн мэдээг хоцорсонд тооцно.

5.9. ТХТН-ийн эмч нар тохиолдлын тодорхойлолтын дагуу бүртгэж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэн, шалгуурт тохирсон өвчтнөөс өдөр бүр сорьц цуглуулна.

5.10. Сорьцыг лабораториид хүргүүлэхээс өмнө интернэтэд суурилсан томуугийн мэдээллийн систем (<http://fis.flu.mn/>)-д бүртгэж, дагалдах хуудсыг бүрэн бөглөнө.

5.11. Цуглуулсан сорьцыг өдөр бүр Дархан-Уул, Сэлэнгэ аймаг өөрсдийн вирус судлалын лаборатори (ВСЛ)-д, Булган, Хөвсгөл, Орхон аймгийн тандалтын нэгжүүд Орхон аймаг дахь ВСЛ, Сүхбаатар, Дорнод аймгийн тандалтын нэгжүүд Дорнод аймаг дахь ВСЛ, Увс, Баян-Өлгий, Ховд аймгийн тандалтын нэгжүүд Ховд дахь ВСЛ, бусад нэгжүүд ХӨСҮТ-ийн ВСЛ-д тус тус хүргүүлнэ.

Хүснэгт 1. Томуугийн харуулдан тандалтын нэмэлт нэгжүүд

№	Нэгжийн нэр	Сум, хилийн боомт	Сорьц хүргэх лаборатори
<b>Нэг. Хилийн боомт</b>			
1	Баян-Өлгий	Цагааннуур, Цагааннуур	Ховд аймаг
2	Дорноговь	Замын-Үүд, Замын-Үүд Хатанбулаг, Ханги	Замын-Үүд сум
3	Дорнод	Чойбалсан, Хавирга Чулуунхороот, Эрээнцав Халхгол, Баянхошуу	Дорнод аймаг
4	Өмнөговь	Ханбогд, Гашуунсухайт Гурвантэс, Шивээхүрэн	Улаанбаатар
5	Сүхбаатар	Эрдэнэцагаан, Бичигт	Улаанбаатар
6	Сэлэнгэ	Алтанбулаг, Алтанбулаг Сүхбаатар, Сүхбаатар	Сэлэнгэ аймаг
7	Увс	Давст, Боршоо	Ховд аймаг
8	Ховд	Булган, Булган	Ховд аймаг
9	Хөвсгөл	Ханх, Ханх	Улаанбаатар
<b>2. Эрүүл мэндийн байгууллага</b>			
1	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	ХӨСҮТ, ВСЛ	
2	Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг	ХӨСҮТ, ВСЛ	
3	Цэргийн төв эмнэлэг	ХӨСҮТ, ВСЛ	
4	Улаанбаатар төмөр замын төв эмнэлэг	ХӨСҮТ, ВСЛ	
<b>3. Амаржих газар</b>			
5	Өргөө	ХӨСҮТ, ВСЛ	
6	Хүрээ	ХӨСҮТ, ВСЛ	
7	Амгалан	ХӨСҮТ, ВСЛ	

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны 11 сарын 11-ны өдрийн тушаалын  
хөрдугаар хавсралт 503

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН  
ЛАБОРАТОРИЙН СОРЬЦ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ,  
МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛЫН ТҮР ЗААВАР

**Нэг. Сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх**

1.1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ыг илрүүлэх, ТТӨ, АЗЦХХ-ын сэжигтэй тохиолдлыг оношилсон эмч эмчилгээ эхлэхээс өмнө сорьцыг авна.

1.2. Хүн амын дунд тандалтын зорилгоор сорьц авч байгаа тохиолдолд багийн бүрэлдэхүүнд сургаж бэлтгэгдсэн лаборант эсвэл сувилагчийг ажиллуулна.

1.3. Амьсгалын замаас сорьц цуглуулах аргачилсан заавар бүхий видео хичээлийг [www.flu.mn](http://www.flu.mn) цахим хуудас, <https://youtube/hOzJ9EzZTe8> холбоосоор үзэж мэргэжилтнүүдийг сорьц авах арга зүйд бэлтгэнэ.

1.4. Сэжигтэй тохиолдол бүрээс хамар-залгиур, ам-залгиурын арчдас, амьсгалын доод замын хүнд хэлбэрийн өвчтэй бол цэр, амьсгалын гууртай бол мөгөөрсөн хоолойн сордос, мөгөөрсөн хоолой-альвеолын лаваж цуглуулна. Нэмэлтээр цус, шээс, өтгөн, шаардлагатай бол уушгинь эд, эсийн сорьц цуглуулж шинжилнэ.

1.5. Сорьц цуглуулах үед өрөөнд байх хүний тоог аль болох цөөлж, зөвхөн өвчтөнд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтныг байлцуулна.

1.6. Шинжлэгдэхүүн цуглуулах эрүүл мэндийн ажилтан нь хамгаалах хувцас, хэрэгслийг бүрэн өмсч, шүүлтүүр бүхий N95 амны хаалт, нүдний шил, нүүрний халхавч зүүнэ.

**Хоёр. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын үед сорьц цуглуулах аргачлал**

2.1. Хамар-залгиурын арчдас цуглуулах:

2.1.1. Өвчтөний нусыг нийлгэх буюу ариун бамбараар хамрын хөндийг арчиж цэвэрлээд, насанд хүрэгсийг хэвтээ эсвэл толгойг 45° өнцгөөр гэдийлгэж, хүүхдийг хүнд тэврүүлж суулгана.

2.1.2. Зүүн гарын эрхий, долоовор хуруугаар өвчтөний хамрын үзүүрээс чимхэж, баруун гартаа ариун бамбар барьж, болгоомжтой зөөлөн эргүүлэх хөдөлгөөнөөр хамрын хөндийн доод хэсгийг дагуулан зөөлөн тагнайтай параллелаар насанд хүрэгч бол 4-5 см, хүүхэд бол 2-3 см оруулна.

2.1.3. Бамбарыг салст бүрхүүлд зөөлөн шахаж эргүүлээд авч, арчдасыг зориулалтын вирус тээвэрлэх уусмал эсвэл 1,5 мл 0,9%-ийн натри хлорид бүхий хуруу шилэнд хийж сайтар таглана.

2.1.4. Сорьц авах үед үйлчлүүлэгч ханиах, найтаах байдлаар халдвартараах эрсдэл ихтэй тул сорьц авах ажилбарыг аль болох цөөн хүнтэй, тусгаар орчинд гүйцэтгэвэл зохино.

2.1.5. Хамар-залгиурын арчдас авахад ариун, уян бамбар ашиглавал зохимжтой бөгөөд сорьц авах ажилбарыг аль болох шуурхай гүйцэтгэх хэрэгтэй.

2.2. Ам-залгиурын арчдас цуглуулах: Үйлчлүүлэгчийг дээрх байдлаар бэлтгэж, суулгаад хатуу иштэй ариун бамбар ашиглан хэл дарагчаар хэлийг дарж, бамбараар залгиурын арын ханыг зөвлөн дарж арчиж авна. Арчдасыг вирус тээвэрлэх орчин бүхий хуруу шилэнд хийж шилийг сайтар таглана. Амыг ангайлгаж, хэл дарагчаар хэлийг дарж, залгиурын арын ханыг ариун бамбараар арчиж авна. Арчдасыг зориулалтын вирус тээвэрлэх уусмал эсвэл 1,5 мл 0,9%-ийн натри хлорид бүхий хуруу шилэнд хийнэ.

2.3. Цэр цуглуулах: Амыг усаар сайтар зайлцуулж, амны хөндийг цэвэрлэн, хамар ба хоолойн салс, шүлс зэргийг аль болох оруулахгүй авна. Амьсгалыг гүнзгий авахуулан, түгжин 2 секунд орчим болсны дараа аажим гаргуулж, энэ үйлдлийг 2-оос доошгүй удаа давтана. Гурав дахь удаагаа амьсгалыг гүнзгий авахуулж, хүчтэй ханиалгуулан цээжний гүнээс цэрийг гаргуулна. Гаргасан цэрийг цэр цуглуулах саванд хийнэ. Цэرنд хэмжээ 3-5 мл байна. Цэрийг агааржуулалт сайтай, зориулалтын өрөөнд эсвэл гадна орчинд авна.

2.4. Эд, эсийн сорьц цуглуулах: Уушкины эдийн гүнээс буюу гуурсан хоолойноос 0.5 см талтай шоо хэлбэртэй отолж аваад, ариун саванд эсвэл зориулалтын вирус тээвэрлэх уусмал бүхий хуруу шилэнд хийж сайн таглана.

#### **Гурав. Сорьц хадгалах, тээвэрлэх**

3.1. Хамар-залгиурын арчдас, ам-залгиурын арчдас, мөгөөрсөн хоолойн сордсыг нийслэлд 24-48 цагийн дотор мөсөн элемент бүхий саванд хийж, +2-оос +8 хэмд тээвэрлэж, лабораторид хүргэнэ. Хөдөө орон нутагт 48 цагийн дотор тээвэрлэх боломжгүй бол -70°C хэмд хадгалж, хөлдүүгээр нь тээвэрлэж, лабораторид хүргүүлнэ.

3.2. Эд, эсийн сорьцыг +2- +8 хэмд тээвэрлэж, лабораторид яаралтай хүргэнэ. Боломжгүй бол -70°C хэмд хадгалж, тээвэрлэнэ.

3.3. Ийлдсийг 7 хоногийн дотор лабораторид илгээх боломжтой бол хөлдөөлгүй сэргүүн нөхцөлд хадгалж, тээвэрлэнэ. Боломжгүй бол -20°C-д хадгалж байгаад хөлдүүгээр тээвэрлэж лабораторид хүргэнэ.

3.4. Сорьцыг тээвэрлэхийн өмнө ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторийн 451183, 455847 дугаарын утсаар, орон нутагт бол харьяа лабораторид урьдчилан мэдэгдэнэ.

3.5. Сорьцыг орон нутгаас томуугийн сорьц тээвэрлэлтийн шугамаар тээвэрлэх боломжгүй тохиолдолд “Сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийн тогтолцоо”-г ашиглана.

3.6. Сорьцыг асгарахаас сэргийлэн биоаюултай илгээмж, биобэлдмэл тээвэрлэх журмын дагуу гурвалсан баглааны зарчмыг баримтална. Сорьц цуглувансан савны гадуур амыг нь битүүмжлэх боломж бүхий уутанд хийж, гадна талд нь “Биоаюултай”, “Халдвартай” гэсэн тэмдэглэгээг хийж тээвэрлэнэ. Сорьцыг

шингээг цаас болон самбайгаар ороон жийрэглэж хоёрдогч саванд хийнэ. Хэд хэдэн сорьцыг хоёрдогч саванд хийж болно. Ингэхдээ тус тусад нь шингээгч материалыар орооно. Уг сорьцоо тусгай пластик саванд хөдөлгөөнгүй байрлуулж таглаад мөсөн элемент бүхий гуравдагч саванд сорьцыг босоо байрлуулна. Савны дотор цельсийн +2-оос +8 хэмийн хүйтэн хэлхээг баримтлан хянах зорилгоор термометр байрлуулж өгнө. Сорьцын дагалдах хуудас (Маягт 1)-ыг гаргацтай, бүрэн бөглөж сорьцын хамт лабораторид хургуулнэ.

#### **Дөрөв. Мэдээллийн урсгал**

4.1. Коронавируст халдварын сэжигтэй болон онош баталгаажуулах тохиолдлоос сорьц цуглуулсан бол сорьц авсан эрүүл мэндийн ажилтан [www.burtgel.mohs.mn](http://www.burtgel.mohs.mn) цахим хуудсанд бүртгэж, хариуг шинжилгээ хийсэн лабораторийн мэргэжилтэн [www.burtgel.mohs.mn](http://www.burtgel.mohs.mn) цахим хуудсанд оруулна.

4.2. ТТӨ, АЗЦХХ-ын тохиолдлоос сорьц авсан үед ХӨСҮТ-д мэдэгдэж, сорьц тээвэрлэхийн өмнө интернэтэд суурилсан томуугийн мэдээллийн систем (<http://fis.flu.mn/>)-д бүртгэж, шинжилгээний хариуг интернэтэд суурилсан томуугийн мэдээллийн систем (<http://fis.flu.mn/>)-ээс авна.

#### **4.3. Сорьц цуглуулахад шаардагдах зүйлс**

- Хамгаалах хувцас хэрэгсэл (шингэн үл нэвтрүүлэх материалыар хийгдсэн халад эсвэл комбинезон, N95 амны хаалт, нүдний шил буюу нүүрний хаалт, нэг удаагийн үзлэгийн бээлий)
- 7-8 см урт уян болон хатуу иштэй ариун бамбар
- Хэл дарагч
- 2-4 мл вирус зөөвөрлөх орчин эсвэл 1,5 мл 0,9%-ийн натри хлорид бүхий бөглөтэй хуруу шил
- Хуруу шил тогтоогуур
- Цэрний сав
- Сорьц тээвэрлэх зориулалтын савууд
- Мөсөн элемент
- Шилний харандаа
- Салфетка
- Термометр
- Сорьц дагалдах хуудас (Маягт)

Маягт. Сорьц дагалдах хуудас №...../.....

## Эрүүл мэндийн байгууллагын нэр .....

Өвчтөний овог/нэр .....

Нас: ..... Хүйс: Эрэгтэй |\_\_|, Эмэгтэй |\_\_|

Гэрийн хаяг: .....

Эмнэлзүйн онош: .....

Өвчин эхэлсэн огноо: \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ өдөр

Эмнэлэгт хэвтсэн огноо: \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ өдөр

Сорьц цуглувсан огноо: \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ өдөр \_\_\_\_ цаг \_\_\_\_ минут

Сорьц цуглуулах үеийн биеийн хэм: |\_\_|\_\_|.1\_|<sup>0</sup>C

Цуглуулсан сорьцын төрөл: Хамар-залгиурсын арчдас | |

## Ам-залгиурын арчдас

## Мөгөөрсөн хоолойн сордос |

Бусад .....

сити — сарын — едер —

Сервърът е бил блокиран от Уебинар заради неподходящо поведение.

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны 11 сарын 11-ны өдрийн 9 тушаалын  
туравдугаар хавсралт  
*ЗСЗ*

## ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМЫН ДУНД ИДЭВХТЭЙ ТАНДАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТҮР ЗААВАР

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зорилтот бүлгийн хүн амын дунд идэвхтэй тандалт илрүүлэг хийж, коронавируст халдвартыг эрт илрүүлж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

1.2. Зорилтот бүлгийн хүн амын дунд Коронавирусын халдварт (КОВИД-19)-ын шинж тэмдэггүй болон хөнгөн хэлбэрээр өвчилсөн тохиолдлыг эрт илрүүлснээр халдвартын тархалтын зэргийг тодорхойлж, хариу арга хэмжээг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх зорилготой.

1.3. Хүн амын дундах идэвхтэй тандалт, илрүүлэг нь халдвартын үе шат, түвшингээс хамаарна. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тархалтыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын удирдамжийн дагуу өөрийн орны онцлогт тохируулан 4 үе, шат болгон тодорхойлов. Үүнд:

1.3.1. **0 үе шат - Өвчний тохиолдол бүртгэгдээгүй үе:** Халдвартын тохиолдол бүртгэгдээгүй эсвэл сүүлийн 28 хоногийн турш шинэ тохиолдол илрээгүй. Нийт хүн ам халдварт авах эрсдэл байхгүй. Энэ үед эрсдэлт бүлгийн (эрүүл мэндийн ажилтан, эмнэлэгт хэвтэж байгаа өвчтөн, эмнэлэгт хандсан үйлчлүүлэгч, архаг суурь өвчтэй хүмүүс, өндөр настан) хүн амаас түүврийн аргаар сонгож, коронавируст (КОВИД-19) халдварт илрүүлэх шинжилгээ хийнэ.

1.3.2. **I үе шат - Зөөвөрлөгдсөн / Алаг цоог өвчлөлийн үе шат:** Сүүлийн 14 хоногт бүртгэгдсэн шинэ тохиолдол зөөвөрлөгдсөн эсвэл хүн амын дунд цөөн тохиолдол бүртгэгдэж, хяналтад бүрэн авсан үеийг хэлнэ. Халдвартын үе шатыг үнэлэх зорилгоор томуугийн харуулдан тандалтын нэгжүүдэд тулгуурлан идэвхтэй тандалтыг зохион байгуулна.

1.3.3. **II үе шат - Голомтолсон өвчлөлийн үе шат:** Сүүлийн 14 хоногийн хугацаанд гарсан шинэ тохиолдлууд нь цаг хугацаа, газарзүйн байршил, тархвар судлалын хувьд хоорондоо холбоотой, хязгаарлагдмал хүрээнд бүртгэгдсэн. Энэ үе шатанд тандалтыг байршмал халдвартын голомтолсон тохиолдлуудыг цомхотгож, халдвартархаас сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагуудын ачаалал хэт нэмэгдэхээс сэргийлэх, олныг хамарсан үйл ажиллагааг хязгаарлана. Халдвартын тархалтын үе шатыг үнэлэх зорилгоор томуугийн харуулдан тандалтын нэгжүүдэд тулгуурлан идэвхтэй тандалтыг зохион байгуулна. Түргэвчилсэн оношлуур болон ПГУ-ын шинжилгээ хийнэ.

1.3.4. **III үе шат - Хүн амын дунд тархсан үе шат:** Сүүлийн 14 хоногийн хугацаанд бүртгэгдсэн шинэ тохиолдлуудын эх уурхай тодорхойгүй, газарзүйн байршил, тархвар судлалын хувьд хоорондоо холбоогүй. Энэ үед шинэ бүртгэгдсэн голомтолсон өвчлөлийг нарийвчлан судлах, томуугийн харуулдан тандалтын нэгжүүдэд тулгуурлан идэвхтэй тандалтыг зохион байгуулна.

Түргэвчилсэн оношлуур болон ПГУ-ын шинжилгээ хийж, хүн амын дундах тархалтын түвшинг тогтооно.

### **Хоёр. Идэвхтэй тандалт зохион байгуулах аргачлал**

2.1. Хүн амд суурилсан идэвхтэй тандалтыг эмнэлзүй, лаборатори болон үйл явдалд суурилсан хэлбэрээр халдвартын тархалтын үе шатаас хамаарч зохион байгуулна (Хүснэгт 1).

2.2. Эмнэлэгт суурилсан тандалтыг тухайн байгууллагын хүний нөөцийн алба аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулна.

2.3. Эмнэлзүйд суурилсан тандалтыг [www.119.mn](http://www.119.mn), цахим хуудас болон шуурхай 119 апплейкшн ашиглан бүх шатлалын эрүүл мэндийн байгууллага, тусгаарлан ажиглах байрны ажилчид, байнгын ажиллагаатай асрамж, халамжийн төв, сургуулийн болон оюутны дотуур байр, цэргийн анги, хорих газар зэрэг байгууллагуудад өдөр бүр тогтмол хийнэ.

2.4. Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд харьяа эрүүл мэндийн байгууллагад мэдээлж, өөрсдийн нөхцөл байдалд тохируулан түр тусгаарлана.

2.5. Лабораторийн тандалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэсэн 2 хэлбэрээр явуулах ба халдвартархалтын үе шатаас хамаарч системтэй, тодорхой давтамжтай зохион байгуулна.

2.6. Төлөвлөгөөт тандалтад бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд, тусгаарлан ажиглах байрны ажилчид, байнгын ажиллагаатай асрамж, халамжийн төв, сургуулийн дотуур байр, цэргийн анги, хорих газар, хилийн нэвтрэх цэгийн ажилчдыг тархалтын үе шатаас хамаарч системтэй, тодорхой давтамжтай хамруулна (Хүснэгт 2).

2.7. Төлөвлөгөөт бус тандалтад нийтийн үйлчилгээний байгууллага (супермаркет, зах, худалдааны төв, шөнийн клуб, зоогийн газар, тоглоомын төв, хүнсний үйлдвэрлэл явуулдаг болон хүргэлт хийдэг аж ахуйн нэгж), банк санхүүгийн байгууллага, нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн ажилчдыг тархалтын үе шатаас хамаарч системтэй, тодорхой давтамжтай хамруулна (Хүснэгт 3).

2.8. Энэ журмын 2.6, 2.7-д тусгагдсан байгууллагад батлагдсан тохиолдол бүртгэгдсэн даруйд тандалтыг өргөжүүлж, бүх ажилтныг шинжилгээнд хамруулж, ойрын хавьталд Эрүүл мэндийн сайдын 2020 оны 269 дүгээр тушаалын дагуу хариу арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.9. Тандалтын мэдээнд дүгнэлт хийж, тайланг тухай бүрт Эрүүл мэндийн яам болон холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг ХӨСҮТ, НЭМҮТ хариуцаж зохион байгуулна.

**Хүснэгт 1. Халдвартын үе шатанд тохируулан тандалт хийх давтамж**

Халдвар тархалтын үе шат	Эмнэлзүйн тандалт	Лабораторит сууринсан тандалт		Үйл явдлын тандалт
		Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус	
Халдвар тархалтын 0 үе шат (Өвчний тохиолдол бүртгэгдээгүй)	Өдөр бүр	2 долоо хоногоос сар тутам	Сар тутам	Өдөр бүр
Халдвар тархалтын 1-р үе шат (Зөөвөрлөгдсөн/Алаг цоог өвчлөл)	Өдөр бүр	2 долоо хоногоос сар тутам	Сар тутам	Өдөр бүр
Халдвар тархалтын 2-р үе (Голомтолсон өвчлөл)	Өдөр бүр	2 долоо хоног тутам	2 долоо хоног тутам	Өдөр бүр
Халдвар тархалтын 3-р үе (Хүн амын дунд халдвар тархсан)	Өдөр бүр	2 долоо хоног тутам	2 долоо хоног тутам	Өдөр бүр

**Хүснэгт 2. Лабораторийн төлөвлөгөөт тандалт хийх давтамж, зорилтот бүлэг**

Халдвар тархалтын үе шат	Тандалтын түүвэр, давтамж
Халдвар тархалтын 0 үе шат (Өвчний тохиолдол бүртгэгдээгүй)	<ul style="list-style-type: none"> <li>- Эрсдэлт бүлгийн (эрүүл мэндийн ажилтнууд, эмнэлэгт хэвтэж байгаа өвчтөн, эмнэлэгт хандсан үйлчлүүлэгч, архаг суурь өвчтэй хүмүүс, өндөр настан) хүн амаас түүврийн аргаар сонгож КОВИД-19 эсрэгтөрөгч илрүүлэх түргэвчилсэн тест болон ПГУ шинжилгээ хийнэ.</li> </ul>
Халдвар тархалтын 1-р үе шат (Зөөвөрлөгдсөн / алаг цоог өвчлөл)	<ul style="list-style-type: none"> <li>- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан болон сэжигтэй тохиолдолтой шууд харилцаж, тусlamж үйлчилгээ үзүүлж буй эмнэлгийн болон бусад ажилчдыг (шуурхай хариу арга хэмжээний баг, лаборатори, эмнэлзүйн тасаг, эмнэлгийн инженер техникийн тасаг гэх мэт) нь долоо хоног тутамд түүвэр аргаар шинжилгээнд хамруулна.</li> <li>- Бусад байгууллагад тасаг, нэгж бүрээс 2 ажилтныг сонгон сард нэг удаа шинжилгээнд хамруулна.</li> </ul>
Халдвар тархалтын 2-р үе (Голомтолсон өвчлөл)	<ul style="list-style-type: none"> <li>- Коронавируст халдварын батлагдсан болон сэжигтэй тохиолдолтой шууд харилцаж, тусlamж үйлчилгээ үзүүлж буй эмнэлгийн болон бусад ажилчдыг (шуурхай хариу арга хэмжээний баг, лаборатори, эмнэлзүйн тасаг, эмнэлгийн инженер техникийн тасаг гэх мэт) нь долоо хоног тутамд түүвэр аргаар шинжилгээнд хамруулна.</li> </ul>
Халдвар тархалтын 3-р үе (Хүн амын дунд халдвар тархсан)	<ul style="list-style-type: none"> <li>- Хүн амын дунд коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэгбие (antibody) илрүүлэх түүвэр шинжилгээ хийж, өвчний тархалт (prevalence) тогтооно. Шинэ голомтолсон өвчлөлийг нарийвчлан судлана.</li> </ul>

**Хүснэгт 3. Лабораторийн төлөвлөгөөт бус хийх давтамж, зорилтот бүлэг**

Халдвартархалтын үе шат	Тандалтын түүвэр, давтамж
Халдвартархалтын 0 үе (Өвчний тохиолдол бүртгэгдээгүй)	<ul style="list-style-type: none"> <li>- Нийтийн болон худалдаа үйлчилгээний байгууллага, банк санхүүгийн байгууллага, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүд халдварын эрсдэлтэй ажилчдын тооноос хамаарч 5 хүртлэх хувийг сард нэг удаа шинжилгээнд хамруулна:           <ul style="list-style-type: none"> <li>○ 1-10 ажилтантай бол 1 хүнийг,</li> <li>○ 11-50 ажилтантай бол алба, нэгж бүрээс 1 хүнийг,</li> <li>○ 51-ээс дээш ажилтантай бол 5%</li> </ul> </li> </ul>
Халдвартархалтын 1-р үе (Зөөвөрлөгдсөн / алаг цоог өвчлөл)	<ul style="list-style-type: none"> <li>- Нийтийн болон худалдаа үйлчилгээний байгууллага, банк санхүүгийн байгууллага, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүд халдварын эрсдэлтэй ажилчдын тооноос хамаарч 5 хүртлэх хувийг сард нэг удаа шинжилгээнд хамруулна:           <ul style="list-style-type: none"> <li>○ 1-10 ажилтантай бол 1 хүнийг,</li> <li>○ 11-50 ажилтантай бол алба, нэгж бүрээс 1 хүнийг,</li> <li>○ 51-ээс дээш ажилтантай бол 5%</li> </ul> </li> </ul>
Халдвартархалтын 2-р үе (Голомтолсон өвчлөл)	<ul style="list-style-type: none"> <li>- Коронавируст халдварт (КОВИД-19)-тай өвчтний ойрын хавьтлыг лабораторийн шинжилгээнд хамруулна.</li> </ul>
Халдвартархалтын 3-р үе (Хүн амын дунд халдвартархсан)	<ul style="list-style-type: none"> <li>- Зорилтот бүлгийн хүн амын дунд Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэгбие (antibody) илрүүлэх түүвэр шинжилгээ хийж, өвчний тархалт (prevalence) тогтооно.</li> </ul>

--ooOoo--